

**ГУТГААР БАЙР ЭЗЭЛСЭН ЭССЭ**  
**ҮЛ ҮЗЭГДЭГЧ ЦАГ БА МӨРӨӨДЛИЙН ХОТ**

*Баяраа овогтой Болор-Ууган  
Нийслэлийн лаборатори Ирээдүй  
цогцолбор сургуулийн 12<sup>б</sup> ангийн сурагч*

Үл үзэгдэгч цагаар хөдөлдөг мөрөөдлийн хотын иргэн

Та бүхэнд мэндчилж байна.

Маргаашийнхаа төлөө өнөөдөр хөдөлдөг манай нийгэмд өмнөх нийгэмд байдаг бүхий л зүйл байгаа. Харин ганц л нэмэгдсэн зүйл нь хүмүүсийн хандлага байсан юм. Бидний үед эх оронч үзэлтэй хүн гэж монгол дээл, гутал, эртний малгай өмсөж, морин хуур тоглодог хүнийг хэлдэггүй. Бид зүгээр л эх оронч байна гэдэг нь сонголт биш гэдгийг ойлгосон. Ерөнхийдөө хоосон цээжээ дэлдэж, худал яригчдаас залхсан бас ичсэн.

Эцэг, эх маань биднийг онц дүн, эд хөрөнгийн төлөө биш хүн шиг хүн болгохын төлөө зүтгэдэг. Аав минь надад газрын зурагт харахад төө хүрэхгүй ч туулаад явахад хэдэн мянган бээр үргэлжлэх уудам нутаг, хил хязгаар, тоолж барамгүй мал сүрэг, ухаж сэндийчиж боломгүй онгон дагшин голомт, ашигт малтмал, мэнд мэдэн уулзахад төсөөлж баршгүй уужим сэтгэлгээ, холч ухаан, саахалт айлаа гэсэн зүрх сэтгэл бүгд чиний эх орон гэдгийг зааж сургасан.

Гэтэл манай хотод эх оронч байх өдөр, эх орноо хайрлах өдөр гэж зарладаггүй. Бид зүгээр л өөрсдийн санаачилгаараа эх орноо хайрлаж бас хамгаалдаг.

Мөн бидэн дунд эх оронч хүн гэж тусдаа байдаггүй бид энд төрсөн л бол энэ бүхэн миний үүрэг хариуцлага гэж ойлгодог болсон. Ерөнхийдөө бидний хандлага төлөвшил өөрчлөгдсөн. Гэрээсээ гараад л бүх эд юмс хүнийх гэдэг бодлоосоо салж илүү өөриймсөг болсон.

Зөвхөн газар ухаж ховордсон ан амьтдыг агнах, гол усаа ширгээх нь л байгаль дэлхийнхээ эсрэг хийж буй зүйл биш юм гэдгийг мэдэрсэн. Идэж яваа чихэрийнхээ цаасыг газарт хаяхад л тэр муу зүйл болно дөнгөж нахиалж буй цэцгийг таслахад тэр эх орныхоо эсрэг хийсэн хорт зүйл болно гэдгийг мэдсэн бас ойлгосон.

Мэдээ мэдээллийн саак.мн –д дурдсанаар бидний хаясан бичгийн цаас 2 жил, төмөр сав 10 жил , тугалган цаас 100 жил, хуванцар сав 180-200 жил, шил 1000 жилийн дараа газарт шингэдэг байна. Үүнээс харахад дор хаяж 12-15 үе маань энэ хаягдлын хор уршгийг амсахнээ хэмээн дурдсан байдаг. Манай мөрөөдлийн хотынхон хогоо дахин боловсруулдаг хүмүүс хогоо халаасандаа хийгээд ойр таарсан хогийн савандаа хийдэг. Хүн хогоо гудамжинд хаях, хогийн саванд хийх нь тухайн иргэний ухамсраас л шалтгаалдаг гэдэг зүй тогтол тогтсон.

Мөн өмнөх нийгэмд хил давж гадаадад сурах нь муу гэдэг байсан бол одоо олон улсад боловсрол эзэмшээд эх орондоо эргэж ирээд сурсан мэдлэг, шинэ зүйлээ туршаад эх орондоо сайхан амьдрахыг, гадаадад олон жил амьдраад тэндээ үр хүүхдээ өсгөөд амьдарсан ч үр хойчдоо эх болсон монгол хэлээ зааж сургахыг эх оронч үзэл гэдэг болсон.

Манай үндэстний аюулгүй байдал иргэдээсээ эхэлдэг.

Аюулгүй байдал гэж юу вэ гэдгийг тодруулж үзвэл УИХ-ын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор шинчлэгдэн батлагдсан “Монгол Улсын үндэстний аюулгүй байдлын үзэл баримтлал”-аас авч үзвэл аюулгүй байдал гэдэг нь үндэстний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг

хэлдэг аж. Үндэсний язгуур ашиг сонирхолд “Монголын ард түмэн соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон үндэсний эв эв нэгдэл, эдийн засгийн бие даасан байдал багтдаг” хэмээсэн байдаг.

Нийт нь нэгийн төлөө, Нэг нь нийтийн төлөө гэдэг шиг манай хотын иргэд бие биенээсээ суралцаж, бие биенээсээ үлгэр дуурайлал авч, эв найрамдалтайгаар цогц нийгмийг бүтээж байгаа нь аюулгүй байдлаа хангаж буй бас нэгэн тус юм.

Бид тусгаар тогтнол гэдэг зүйлийг маш сайн ойлгосон. Бид хятадын колони улс болоход тун ойрхон байсан ч ард иргэдийнхээ ухамсарт хандлагаар аврагдсан юм. Тусгаар тогтнол гэдэг нь энгийнээр хэлэхэд аливаа улс үндэстэн хэнээс ч юунаас ч бүх талаараа бие даан, хараат бусаар оршин тогтнож, аж төрөхийг хэлдэг. Аливаа улс тусгаар тогтносон бүрэн эрхт байх гол шалгуурт:

Өөрийн гэсэн сүлд, туг, далбаа, тамга, дуулал, үндэсний хэл бичиг, төрт ёс түүх соёлтой байх гэх мэт зүйлс ордог байна.

Би уншигч танаас асууя. Тусгаар тогтнол гэдэг хичнээн чухал вэ?

2016 оны 03 сарын 04-нд мэдээ мэдээллийн монгол мэдээ.мн-д Түвдийн 16 настай хүү өөрийгөө шатааж эсэргүүцлээ илэрхийллээ хэмээх гарчигтай нийтлэл тавигдсан байх бөгөөд үүнд Энэтхэгт амьдардаг 16 настай түвд хүү өөрийгөө шатааж Бээжингийн эсрэг эсэргүүцлээ илэрхийлсэн бөгөөд азаар хүүд цаг алдалгүй эмнэлэгийн тусламж үзүүлсэнээр амьд үлдэж чадсан тухай байлаа. Бээжингээс тусгаар тогтнолоо авахыг хүссэн түвдийн лам нар өөрийгөө шатааж эсэргүүцлээ илэрхийлж, олон улсын анхаарлыг татахыг хичээдэг. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Түвдийн 158 хүн өөрийгөө шатааж нас барсан байдаг. Энэ хүмүүс эх орныхоо бас бусдын төлөө өөрийнхөө амийг тэвчиж байгаа шүү дээ. Лалын шашинтнууд шиг Аллах Акбараас өөрийг хэлэлгүй хэн нэгнийг нудрах эсвэл бие биендээ бөмбөг зүүж түүнийгээ ажиллуулах товч дарах хоёр бол өөрийгөө шатаахтай зүйрлэвэл ч ёстой үгээр хэлэхийн аргагүй биз ... Энэ бүхний дүгнэлтийг танд үлдээе.

Энэ бүхнээс би эх орон, тусгаар тогтнол гэж яг юу вэ? хэмээх асуулттай тулгарсан юм. Энэ асуудлын хүрээнд би олон нийтийн сүлжээний 120 хүнээс эх орноо цөөн үгээр тодорхойлооч хэмээн асуухад 57 нь “энэ тухай бодож үзээгүй” хэмээн хариулсан бөгөөд 42 хүн нь “газар нутаг” гэсэн бол 21 нь “ээж” гэж хариулсан бөгөөд надад хамгийн сонирхолтой санагдсан хариулт нь 12 дугаар ангийн Э.Баттэргэлийн хариулт байсан юм. Тэр “Эх орноо цөөн үгээр тодорхойлооч” гэхэд “Хөөрхөн охин” гэж хариулсан бөгөөд үүнийхээ учрыг тодруулаач гэхэд тэр “Улс үндэстний хүн бүр нүүрний хэлбэр дүр төрхөөрөө ялгагддаг. Монгол хүн гэдэг чинь нүдэнд дулаахан, зөв дүр төрхтэй гээд маш олон өөр шинжтэй байдаг” гэж хэлсэн.

Тэгэхээр эх орон гэдэг зүйл нь тухайн улсын хүн ард нь ямар байхаас тодорхойлогддог байна. Харин эх оронч үзлийн тухайд... гадаах байдалд ач холбогдол өгдөг цаг дуусаад, дотогшоогоо чиглэсэн буюу хүний зүрх сэтгэлд юу байдаг тулгуурлахыг хэлдэг аж.

Миний бодлоор бугуйнд зүүсэн цагаар бус бидэнд үл мэдэгдэн урсах үл үзэгдэгч цагаар явдаг болсон. Хэн эх оронч вэ гэдэг нь дотроосоо харагддаг болсон манай нийгмийн хүмүүсийн зөв хандлага манай нийгмийн үндэстний аюулгүй байдлыг аврах болно.

#### **Ном зүй:**

- С.Эрдэнэ “Миний эх орон миний тоонот” 2013
- Н.Баатархуяг “Миний эх орон” 2016
- Д.Эрдэнэбат “Хагархай шиг эх орон минь” 2012